



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/291


Улаанбаатар хот

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагад
дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм батлах тухай

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа С.Залуухүү)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2017 оны 11 дүгээр сарын 28 ны өдрийн
А/291 дүгээр тушаалын хавсралт



**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГАД ДАГАЖ МӨРДӨХ
ГАЛЫН АЮУЛГҮЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон холбогдох хууль тогтоомж түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг үндэслэн энэхүү дүрмийг Монгол улсын нутаг дэвсгэр дээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын аж ахуйн нэгжид өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дагаж мөрдөнө.

Хоёр. Ерөнхий шаардлага

2.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын барилга, байгууламжийн дээврийн хөндий, таазны модон хийц, тайз чимэглэлийн хатуу, зөөлөн эдлэлүүдэд галаас хамгаалах нэвчилгээ хийлгэнэ.

2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын барилга байгууламж руу очих зам, гарц чөлөөтэй, усан хангамж, барилгын дотор усны цэгийг ашиглах боломжтой байлгах ба засвар үйлчилгээ хийх болон бусад шалтгаанаар зам, гарцыг хаах, тоног төхөөрөмж, эд материал хадгалах, хураах газар болгон ашиглаж болохгүй.

2.3. Барилга, байгууламжийн аянга хамгаалагч, тоног төхөөрөмжийн газардуулга нь ажиллагаатай байна.

2.4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын барилга, байгууламжийн өрөө тасалгаа, агуулах, хадгаламжийн сан нь норм дүрэмд заагдсан галын дохиоллын систем, гал унтраах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байнгын ажиллагаатай байна.

2.5. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын бүх ажилтан ажилчид, уран бүтээлчид галын аюулгүй ажиллагааны зааварчилга авна.

2.6. Гал унтраах тоног төхөөрөмж, гал эсэргүүцэх хөшиг, утааны өрх, спринклер, дренчерийн систем ажиллагаагүй үед олон нийтийн арга хэмжээ явуулахгүй.

2.7. Шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээг цаг хугацаанд нь явуулж, холбогдох бичиг баримтыг хөтлөх тэрчлэн галын аюулд хүргэж болох зөрчил бүрийг засч арилгуулсан байна.

2.8. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагад гал түймэр гарсан үед захиргааны болон техникийн ажилтан, ажилчид, уран бүтээлчид, үйлчлэгч нарын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон заавар, хүмүүс, эд материалыг аврах төлөвлөгөө заавал байх бөгөөд заавар төлөвлөгөөг хүн бүр сайтар мэдэж байх үүрэгтэй.

Мөн музей, үзэсгэлэнд үзмэр, бусад үнэт зүйлсийг аврах төлөвлөгөө, циркт бол амьтдыг аврах төлөвлөгөө байна.

2.9. Гал түймрийн үеийн утаа зайлуулах болон агааржуулалтын системийг жилд 2-оос доошгүй удаа шалгаж цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хийнэ.

2.10. Барилгын өрөө тасалгаа, агуулах, хадгаламжийн сангуудад гагнуур хийх, ил гал гаргах зайлшгүй шаардлага гарвал галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд хийнэ.

2.11. Цахилгаан шугам сүлжээ, хуваарилах байгууламжид мэргэжлийн байгууллагаар жилд 2-ээс доошгүй удаа үзлэг шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулна.

2.12. Соёл, урлагийн байгууллагын цахилгааны хяналт нь нэг нэгнээсээ үл хамаарах 2-оос доошгүй тэжээлийн эх үүсвэртэй байна.

2.13. Цахилгаан гэрэлтүүлэх хэрэгслийг цахилгаан хэлхээнд холбож байгаа дамжуулагч утас, кабел нь механик гэмтэлд өртөхөөргүй хийгдсэн байна.

2.14. Гал унтраахад ашигладаг үндсэн болон нөөц насос нь байнгын бэлэн байдалд байна.

2.15. Цахилгаан тоног төхөөрөмж, аппарат, техник хэрэгслийг зөвхөн мэргэжлийн ажилтан хариуцан ажиллуулна.

2.16. Засвар үйлчилгээнд ашиглах шатах тослох материал арчих даавууг зориулалтын төмөр саванд хадгална.

2.17. Халаах, буцалгах зориулалтын хэрэгслийг зөвхөн даргын тушаалаар зөвшөөрөгдсөн өрөөнд галын аюулгүйн шаардлагыг хангасан нөхцөлд хэрэглэнэ.

2.18. Химийн төрөл бүрийн бодис, материал ашиглах нөхцөлд дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ.

а/ хялбар авалцан асах, тэсэрч дэлбэрэх, галын аюултай химийн төрөл бүрийн хуурай болон шингэн бодис материалыг зориулалтын өрөөнд галын аюулгүйн шаардлагыг хангасны үндсэн дээр хадгалах,

б/ хялбар авалцан асах шингэнийг (ацетон, спирт гэх мэт) ажил үйлчилгээнд хэрэглэхдээ 0,5 литрээс ихгүй хэмжээгээр таглаа бүхий саванд хадгалах,

в/ химийн бодис, уусмалтай савны гадна талд тэдгээрийн нэр, химийн томьёо, онгойлгох тэмдгийг бичиж наасан байх,

2.19. Галын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн шинэ техник, технологи нэвтрүүлэх болон галын дохиоллын систем, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авахад шаардагдах төсөв зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

2.20. Галын техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий инженер техникийн ажилтнуудаас бүрдсэн Галын аюулгүй байдлыг хангах сайн дурын бүлгэм томилон ажиллуулах.

2.21. Галын аюулгүй байдлыг хангах сайн дурын бүлгэмийн ажиллах журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага батлан мөрдүүлнэ.

2.22. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын газрууд нь олныг хамарсан үйл ажиллагааны өмнө галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж буй эсэхийг нь мэргэжлийн байгууллагаар шалгуулж илэрсэн зөрчлийг арилгасан байна.

2.23. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засвар үйлчилгээ хийхдээ зураг төсөлд магадлал хийлгэсэн байх.

2.24. Ажил тарсны дараа бүх өрөө тасалгааг шалгаж, гал түймэр гарч болох зөрчлийг арилгах арга хэмжээг авна. Өрөөнүүдийг шалгах журмыг байгууллагын дарга тогтооно. Тухайн байгууллагын жижүүрийн өрөөнд бүх өрөө тасалгааны нөөц түлхүүрийг хадгална.

2.25. Тоглолт, томоохон сургуулилтын үед галын аюулгүй байдал хариуцсан ажилтан нь хяналт тавина.

2.26. Зөөврийн цахилгаан гэрэлтүүлгүүд нь хамгаалалтын тортой, зүүж дүүжлэхэд зориулсан дэгээтэй байна.

2.27. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагад гал гарсан тухай мэдээлэх хэрэгслээр хангаж, Гал түймэр унтраах, аврах ангийг дуудах журмыг байрлуулна.

2.28. Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл төлөвлөх барилга, байгууламжийн жагсаалтын дагуу тоноглож, бүрэн бүтэн байдлыг томилогдсон ажлын хэсэг улиралд 1 удаа, хариуцсан ажилтан өдөр бүр шалгана.

Шалгалтад дараах зүйлүүд хамаарна.

а. гал мэдээлэх дохиоллын хэрэгслийн хүлээн авах станц ажиллагаатай эсэх,

б. гал мэдээлэх дохиоллын хэрэгсэлд тавиур, тоглолтын материал, бусад эд зүйлсийг тулгаж хураахгүй байх ёстой,

в. Галын мэдээ авах хяналтын самбарын өрөөнд хүнд харагдахуйц газар мэдээлэгчүүдийн байршлын схемийг байршуулсан эсэх, тоног төхөөрөмжид үйлчилгээ хийх, мэдээлэгчийн шугаманд гэмтэл гарах, гал гарсан тухай мэдээг хүлээн авмагц гүйцэтгэх үүргийн тухай заавар бэлэн байгаа эсэх,

г. гал гарсан тохиолдолд гүйцэтгэх үүрэг, гал унтраах автомат төхөөрөмж, гал мэдээлэх дохиоллын хэрэгсэл дээр ажиллах зааврыг ажилтан ажиллагсад хүмүүс мэдэж байгаа эсэх,

д. шугам кабелийн бүрэн бүтэн байдал, хана, хамар ханаар нэвтрэн гарч байгаа хэсэгтээ механик гэмтлээс хамгаалагдсан эсэх,

е. галын дотор усны цэгийн иж бүрдэл бүрэн эсэх.

2.29. Галын автомат дохиоллын системийн хүлээн авах хяналтын самбарыг 24 цагийн байнгын жижүүрийн өрөөнд суурилуулна.

2.30. Насосны станцын өрөөнд дотор усан хангамжийн тодорхой схем, түүнчлэн спринклер, дренчерийн систем, хүч нэмэгдүүлэх насосуудыг ажиллуулах хаалтууд дээр тэдгээрийн зориулалт, ажиллуулах журмыг бичиж тавина.

Насосны станцын өрөө, объектын галын хэсэгтэй утсан болон бусад холбоогоор холбогдоно.

2.31. Галаас хамгаалах хөшиг, спринклер, дренчерийн төхөөрөмж, галын дотор усан хангамж, галын холбооны хэрэгсэл, дохиоллын системийн ажиллагааг зөвшөөрөлгүйгээр түр буюу бүр мөсөн салгахыг хориглоно.

2.32. Соёлын байгууллагын гал унтраах тоног төхөөрөмж, галаас хамгаалах хөшиг, утааны өрх, спринклер, дренчерийн систем ажиллахгүй байгаа үед олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглоно.

2.33. Шашны байгууллагууд нь ил гал, лаа, дэн, зул хэрэглэхдээ аюулгүй ажиллагааг сайтар хангаж шатдаггүй суурин дээр, орчин тойрондоо цонож шатахааргүй байрлуулна.

2.34. шашин мөргөлийн газарт байгаа даавуу, мод зэрэг шатдаг материал, барилгын модон хийц бүтээцэд галаас хамгаалах нэвчилгээг 2 жил тутамд 1 удаа хийж баримтжуулсан байна.

2.35. Шашны байгууллага, сүм хийд нь гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгслээр тоноглогдсон байна.

Гурав. Театр, соёлын төв

3.1. Театр, соёлын төв, үзвэрийн газруудын үзэгчдийн танхим, индэрийн сандлуудыг эгнээний дагуу холбож, шаланд сайтар бэхэлсэн байна. 12-оос ихгүй суудалтай давхарлага (лоож) нь тусгай гарцтай тохиолдолд сандлуудын бэхэлгээг хийхгүй байхыг зөвшөөрнө.

3.2. 200-гаас ихгүй хүний багтаамжтай, бүжиг, үдэшлэг зохион байгуулах зориулалттай үзэгчдийн танхимд сандлуудыг хооронд нь холбосон бол шаланд бэхлэхгүй байж болно.

3.3. Тайзны хүрээ нь модон хийцтэй, засал, чимэглэл нь шатдаг материалаар хийгдсэн, үзэгчдийн танхим, үзмэрийн өрөө, буфет, фойены хөшиг, цэмбэн доторлогоотой бол эдгээрт галаас хамгаалах нэвчилгээ хийлгэж, чанарыг жилд 1 удаа шалгана. Энэхүү ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн галаас хамгаалах нэвчилгээ хийсэн хугацаа, дуусах хугацааг тусгасан баримт нь байгууллагын удирдлагад хадгалагдана.

3.4. Театр үзвэрийн газрын тайзны хэсэгт нэг дор хоёроос ихгүй тоглолтын тайзны засал чимэглэл, тоноглол байрлуулж болно.

3.5. Үзэгчдийн танхимын дор байрласан зоорийн давхар, шатны хонгилын талбайд төрөл бүрийн материал эд материал хадгалахыг хориглоно.

3.6. Тайзны чимэглэлийг хийхдээ тайзны эргэн тойронд 1 м-ээс багагүй өргөнтэй тойрог хэлбэрийн хүн явах чөлөөтэй зам үлдээнэ. Тайз харанхуй болох үед энэхүү чөлөө нь цахилгаан гэрлээр гэрэлтүүлэгдсэн байна. Тоглолтын дараа бүх засал, чимэглэлийн зүйлсийг хурааж тусгай агуулахад хийнэ.

3.7. Тайзнаас гарах бүх хаалга, гарцууд ашиглахад бэлэн байдалд байнга чөлөөтэй байна.

3.8. Тайзан дээр тамхи татах, ил гал (бамбар, лаа г.м) гаргах, галын наадам хийх, пиротехник болон бусад хэлбэрийн ил гал гаргахыг хориглоно. Хэрэв зайлшгүй шаардлагатай бол Онцгой байдлын байгууллагатай урьдчилан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гүйцэтгэнэ.

3.9. Тайзны шалан дээр суурин гэрэл байрлуулах үед доор нь заавал шатдаггүй материалаар дэвсгэр тавина.

3.10. Тайзан дээр галаас хамгаалах хөшиг буух хилийг улаан шугамаар тэмдэглэсэн байна. Энэхүү шугамыг давуулан тайзны чимэглэлийн болон бусад зүйлс байрлуулахыг хориглоно.

3.11. Тоглолтын дараа галаас хамгаалах хөшгийг буулгана. Галаас хамгаалах хөшиг нь түгжээнд (зөөлөн дэр) бүрэн тулж байх ёстой.

3.12. Утаа зайлуулах хавхлагыг өвлийн улиралд дулаалах ба 10 хоногт нэгээс доошгүй удаа ажиллагааг нь шалгана.

3.13. Тоглолтын материал, эд материал хадгалах агуулахад 1,5 м-ээс багагүй өргөнтэй чөлөө гаргаж тайзны засал чимэглэл, тоглолтын материалыг хэсэг хэсгээр нь хураана.

3.14. Театр, үзвэрийн газруудын үзэгчдийн танхимд зураг төсөлд заасан хэмжээгээр сандлыг байрлуулна.

3.15. Тайзны хэсэг дэх шатны нугалбар, хаалганууд нь гал эсэргүүцэх өөрөө хаагддаг хаалгатай байна.

3.16. Зөөлөн эдлэлийн агуулахын таазыг үл шатах материалаар хийнэ.

3.17. Театр, соёлын төвийн тайзны кармануудад тайзны засал чимэглэлийн болон тоглолтын материал 2 тоглолтынхоос илүүгүй байж болно. Тайзан дээр тоглолтын эд материал хадгалах газрыг тодорхой зааж тэмдэглэсэн байна. Тоглолтын бусад материал тайзны засал чимэглэлийг соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн гадна, тусгай агуулахад хадгална.

3.18. Үзэгчдийн танхимын доорх подвал, шат, дээврийн хөндий, сам тааз, трюмп жүжгийн хэрэгсэл, материал, аж ахуйн эд материал хадгалахыг хориглоно.

3.19. Галерей, сам тааз, трюм нь байнга чөлөөтэй цэвэр байх ёстой. Трюмд туслах чанарын засварын газар агуулах байгуулахыг хориглоно.

3.20. Тайзны засал чимэглэл тоглолтын материалыг өргөхөд зориулсан олс татуурганы үзүүрийг тус тусад нь тусгай дэгээнд өлгөсөн байна.

3.21. Тайзны чимэглэлийн материалыг галаас хамгаалах нэвчилгээ хийгээгүй үед тоглолтонд хэрэглэхийг хориглоно.

Дөрөв. Музей, үзэсгэлэн

4.1. Музей, зургийн үзэсгэлэнгүүдэд захиргаа, аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа зоорийн давхрын өрөөнөөс гарах хаалга нь үзмэрийн танхим, сан хөмрөг руу орох хаалганаас тусдаа байх ёстой.

4.2. Зургийн үзэсгэлэн, музейн барилгад сүүн гэрэл тавихдаа шатах үзмэр хийцүүдээс 0,3 м-ээс багагүй зайд байрлуулна. Шатдаг материалаар хийгдсэн хөшиг, үзмэр, самбарууд нь улайсдаг гэрлийн шилнээс 0,5 м-ээс багагүй зайтай байна.

4.3. 450 м²-аас илүү талбайтай зургийн үзэсгэлэн, музейн сан хөмрөг, гар бичмэл, ховор ном хадгаламжийн байрыг галаас хамгаалах ханаар хэсэглэн хуваана. Сан хөмрөгүүдэд гал унтраах автомат төхөөрөмжтэй бол галаас хамгаалах ханаар тусгаарласан хэсгийн талбайг 2 дахин нэмэгдүүлж болно.

4.4. Зургийн үзэсгэлэн, музейн сан хөмрөгүүдийн гол замын өргөн нь 2,5 м-ээс багагүй, сан хөмрөгүүдийн тавиуруудын хоорондох зай 0,9 м-ээс багагүй байна.

4.5. Соёлын дурсгал, дүрслэх урлаг, уран зургийн үзэсгэлэн, музейнүүдийн үзмэрийн хэсэгт үзэгчдийн явах замыг хүмүүсийн урсгал өөд өөдөөсөө нийлэхгүй байхаар зохион байгуулна. Үзмэр, самбаруудын хоорондох зай 2 м-ээс илүүгүй гол зай нь 3 м-ээс багагүй байна.

4.6. Шатдаг материалаар хийсэн тавиур тавцан, самбар, зөөлөн эдлэл чимэглэлүүд, хэрэв музейн үнэт зүйлс үзмэр хадгалах нөхцөлд харшлахгүй бол галаас хамгаалах нэвчилгээ хийнэ.

4.7. Музейн барилга, өрөө тасалгааг өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад түрээслүүлэхийг хориглоно.

4.8. Зургийн үзэсгэлэн, музейд хурал, үдэшлэг гэх мэт арга хэмжээг явуулахдаа галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан, зөвхөн дээрх арга хэмжээнүүдийг явуулахаар тоноглогдсон өрөөнүүдэд хийж болно.

4.9. Зургийн үзэсгэлэн, музейн барилгуудад кино гаргахдаа Онцгой байдлын байгууллагатай зөвшөөрөлцсөний үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.10. Зургийн үзэсгэлэн, музейн барилгад баллонтой хий, хялбар авалцан асах, шатах шингэн, галын аюултай бусад бодис материал хадгалахыг хориглоно. Эдгээр бодис материалыг галын аюулгүйн шаардлагыг сайтар хангасан, тусгай агуулахад хадгална.

4.11. Зургийн үзэсгэлэн, музейн сан хөмрөг, үзмэрийн танхимд засварын болон аж ахуйн бусад ажил хийхдээ зөвхөн дарга, захирлын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

Тав. Номын сан

5.1. Номын фондод номын тавиуруудын хооронд дараах зай хэмжээг баримтална. Үүнд: гол гарц 1,2 м, тавиуруудын хооронд 0,75 м, тавиур, барилгын хананы хооронд 0,5 м-ээс багагүй зайтай байна.

5.2. Номын тавиурыг шатдаггүй материалаар хийнэ.

5.3. Хадгалах нөхцөлд харшлахгүй бол хуучны ном, сударт галаас хамгаалах нэвчилгээ хийнэ.

Зургаа. Боловсрол, шинжлэх ухааны байгууллага

6.1. Тэсрэх болон галын аюултай бодис материал ашиглан туршилт шинжилгээ явуулдаг тоног төхөөрөмжүүдийг зөвхөн байгууллагын удирдлагын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авсны дараа ажиллуулна.

6.2. Туршилт шинжилгээний ажлын удирдагч нь тухайн ажлын явцад галын аюулгүй байдлыг хангах шаардлагатай бүх арга хэмжээнүүдийг авна.

6.3. Лаборатори болон бусад өрөө тасалгаануудад нэг ээлжинд шаардагдах хэмжээнээс ихгүй хялбар авалцан асах шингэн, шатах шингэнийг хадгалахыг зөвшөөрнө. Шингэнийг аюулгүй, битүү саванд хийж өрөө тасалгаанд хүргэнэ.

6.4. Эвдрэлтэй болон агааржуулалтын системийг ажиллуулаагүй сорох шүүгээ ашиглах, түүнчлэн шүүгээнд тухайн ажиллагаанд шаардлагагүй тоног төхөөрөмж, бодис материал хадгалж болохгүй.

6.5. Ширээнээс урсах шингэнийг хязгаарлах зориулалтын хашлага ирмэг нь завсар зайгүй бүтэн байх.

6.6. Ажлын өдрийн төгсгөлд ашигласан хялбар авалцан асах шингэн, шатах шингэнийг зориулалтын таглаатай саванд хийж лабораторийн ажилтанд хүлээлгэн өгнө.

6.7. Хялбар авалцан асах шингэн, шатах шингэнийг усны шугам, бусад сувгаар асгах, юүлэхийг хориглоно.

6.8. Туршилтын дараа хялбар авалцан асах шингэн, шатах шингэн хэрэглэсэн савуудыг галын аюулгүйн зориулалтын уусмалаар угааж цэвэрлэнэ.

6.9. Сургалтын анги, танхимуудад зориулалтын тавилга, хэрэгсэл, загвар, үзүүлэн, гарын авлага ашиглахыг зөвшөөрөх ба тэдгээр нь тусгай шүүгээ, тавиурууд дээр байрласан байна.

6.10. Анги, танхимуудад байх ширээний тоо нь зураг төслийн нормд заагдсан хэмжээнээс ихгүй байна.

6.11. Оюутан, суралцагсдад галын аюулгүй байдлыг хангах дүрмийн талаар хичээл сургалтыг зохион байгуулсан байна.

6.12. Хичээлийн дараа удирдан явуулсан багш нь анги, танхим, лаборатори дахь тэсрэх болон галын аюултай бодис материалуудыг хураан тусгайлан тоноглогдсон өрөөнд хийж хадгална.

6.13. Хүүхдийн зуслангийн зориулалттай барилга нь шууд гадагшаа гарах хоёроос доошгүй аврах гарцтай байх ба модон барилга бол зөвхөн нэг давхар байна.

Дараах зүйлийг хориглоно:

а) барилгыг галын аюулын дунд зэрэг шатдаг Ш2-оос доош ангиллын материалаар (сүрэл, зомгол, зэгс, хөөсөнцөр г.м) хийх;

б) хүүхдийг модон барилгын дээврийн давхар болон хоёр аврах гарцтай байх шаардлагыг хангахгүй өрөө тасалгаа, барилгад байрлуулах;

в) хүүхдийн зуслангийн модон барилгыг гал тогоо болон угаалгын газрын зориулалтаар ашиглах;

г) модон болон бусад шатдаг материалаар хийгдсэн барилгад 50-иас дээш хүүхэд байрлуулах;

д) зуны улиралд хүүхэд хичээллэх өрөө тасалгаанд хялбар шатах шингэн, хий, цахилгаан халаах хэрэгсэл хэрэглэх;

6.14. Хүүхдийн зуслангийн барилга нь утсан холбоо болон гал түймрийн үед түгшүүрийн дохио өгөх хэрэгслээр хангагдсан байна.

6.15. Эдгээр барилгуудад шөнийн цагт шалгалт хийх 24 цагийн жижүүр томилно. Жижүүрийн байр нь утсан холбоотой байна.

Долоо. Цирк

7.1. Байнгын болон нүүдлийн циркийн барилга байгууламжийг жил бүр улирлын тоглолт эхлэхийн өмнө мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг гаргуулна.

7.2. Задгай талбайд ил гал хэрэглэсэн үзүүлбэр явуулахдаа гал түймрийн улсын хяналтын байцаагчтай зөвшилцөн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээг найруулагч хариуцан зохион байгуулна.

7.3. Циркийн дээр (шапито) нь үл шатах материалаар хийгдсэн байна. Хэрэв шатамхай материалаар хийсэн бол галаас хамгаалах нэвчилгээ хийнэ.

7.4. Амьтдын хоол тэжээл бэлтгэх гал зуух нь циркийн өрөө тасалгаанаас үл шатах хана, таазаар тусгаарлагдана. Хоол тэжээлийг бэлтгэхэд түр маягийн цахилгаан плитка хэрэглэх, циркийн хашааны гадна чанаж буцалгахыг хориглоно

7.5. Циркийн барилгын шал, ханыг үл шатах материалаар хийнэ.

7.6. Зөөврийн цахилгаан станц байрлуулсан автомашины чиргүүлийг орон сууц, засаг захиргааны барилга байгууламжид 10 м-ээс ойргүй зайд үзэгчид, амьтдыг аврах замыг таглахааргүй байрлуулна.

7.7. Циркийн үзэгчдийн тоо нь техникийн паспортонд заасан суудлын тооноос илүүгүй, суудлын байрлал нь барилгын норм, дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Үзэгчдийн заалны шал нь тэгшхэн, босго шатгүй байхын дээр бүх суудлыг өөр хооронд нь холбож, шаланд нь сайтар бэхэлсэн байна.

7.8. Циркийн манеж нь үзэгчдийн заалнаас 0,5 м-ээс багагүй өргөнтэй хаалтаар тусгаарлагдсан байх ба үзэгчдийн заалны 1-р эгнээний суудал хүртэл 1 м-ээс багагүй зайтай байна.

7.9. Амьтны өрөөнөөс гадагшаа шууд гарах бие даасан 2-оос доошгүй хаалгатай байна. Хаалганууд, түүний дотор бэлтгэл хаалгануудыг хялбархан тайлагдах түгжээгээр түгжинэ.

7.10. Гал түймрийн үед мал, амьтдыг гаргахдаа маллагч, сургагчаас заавар авч ажиллана.

7.11. Циркийн өрөөнүүдэд ажлын гэрэлтүүлгээс гадна цахилгаан тоног төхөөрөмжийн угсрах дүрмийн дагуу аваарын гэрэлтүүлэг хийнэ.

7.12. Манежийн ажлын гэрэлтүүлэгт зориулсан битүү арматуртай цахилгаан гэрлийн хэрэгсэл ашиглана.

7.13. Хүчдэлийг тохируулагч бүх цахилгаан хэрэгслүүдийг гэрэлтүүлгийн өрөөнд байрлуулах ба гэрлийн өрөө нь манеж, бусад өрөөнүүдээс үл шатах хана, хучилтаар тусгаарлагдсан байна.

7.14. Хурц гэрэлтүүлгийн лампууд нь өнгөт шил, гэрлийн шүүлтүүр, үл шатах нимгэн, тунгалаг хальс, металл тороор хамгаалагдсан байна. Гэрлийн шил нь харласан хэлбэр дүрсээ алдаж цүлхийсэн үед түүнийг яаралтай солих ёстой.

7.15. Мал, амьтдын байрны цахилгаан гэрэл нь битүү шилэн бүрхүүлтэй байна. Араатан амьтны тор нь зөөвөрлөхөд хялбар, дугуйтай байна.

7.16. Амьтад зөөвөрлөх автомашин нь техникийн хувьд бүрэн бүтэн байхын дээр гал унтраагуур, асбест болон зузаан даавуун бүтээлэг бэлдсэн байна.

Машины тэвш дээр амьтадтай хамт аккумулятор, спирт, хүчил, ацетон, бензин болон бусад галын аюултай бодис материал тээвэрлэхийг хориглоно.

7.17. Мал, амьтны байранд 1 хоногийн тэжээлийн нөөц хадгалах байр барьж болно. Тэжээлийн бусад нөөцийг аж ахуйн хашаанд тусгай агуулахад хадгална.